



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/61

Арвайхээр

Нутгийн захиргааны байгууллагын 2020 оны үйл  
ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ,  
үнэлгээний дүнгийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн а/552 дугаар захирамжаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын 10 дугаар зүйлийн 10.13.а, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нутгийн захиргааны байгууллагын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тэргүүлсэн Хайрхандулаан, Нарийнтээл, Хужирт, Есөнзүйл, Арвайхээр сумдыг тус бүр 2.000.000 (хоёр сая) төгрөг, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газрыг тус бүр 1.000.000 (нэг сая) төгрөгөөр шагнасугай.

2.Шагналын зардалд шаардагдах 13,000,000 (арван гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3.Үйл ажиллагааны үр дүнгээр тэргүүлсэн аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар, аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Хайрхандулаан, Нарийнтээл, Хужирт, Есөнзүйл, Арвайхээр сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын дарга нарт тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс олгохыг нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100132